

National
Datacenter




DCERT

DATACENTER EMERGENCY RESPONSE TEAM

ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

OpenSnitch Is a Host-Based Firewall for Linux Desktops



Зимпериум-ын судалгааны газрын дэд ерөнхийлөгч Симон Маргарителли Литтл Снитч (Little Snitch) буюу MacOS-ын галт ханын Линукс-д зориулсан хувилбарыг бүтээжээ.

ОпенСнитч (OpenSnitch) нь MacOS дэхь хувилбартай адилаар Линукс системд хэрэгжүүлэх боломжтой, хост дээр ажиллах галт хана юм. Энэ програм нь системд ажиллаж буй програмаас гадагшаа чиглэсэн шинэ холболт үүсгэх оролдлого хийгдэх үед хэрэглэгчид анхааруулга өгдөг байна.

Литтл Снитч (Little Snitch)-ийн энгийн холболт хийгдэх хүсэлт ирэх үед дэлгэцэнд анхааруулах мессеж гаргах бөгөөд хэрэглэгчээс энэхүү шинэ процессыг хэрхэн үргэлжлүүлэх талаар асууна.

Хэрэглэгчийн шийдвэр бүрийг дүрэм болгон локал JSON файлд хадгалдаг. Энэхүү дүрмийг хэрэглэгч дараа нь сайжруулах эсвэл импорт/экспорт хийх гэх мэт үргэлжлүүлэн ашиглах боломжтой байна.

Энэ програм нь Go болон Python програмчлалын хэл дээр бичигдсэн бөгөөд “systemd”-ийг дэмжин ажиллахаас гадна график интерфэйсдээ Qt5 график интерфэйсийг ашигласан байна. ОпенСнитч (OpenSnitch) нь албан ёсоор гараагүй боловч Маргарителли өөрийн твиттер хуудаснаа 1.0.0 хувилбар бэлэн болсон бөгөөд энэ хувилбар нь эцсийн бүтээгдэхүүнд гэж хэлж болохуйц хөгжүүлэлт хийгдсэнийг мэдээлжээ.

10 жил орчим хөгжүүлэлт хийгдсэн Литтл Снитч програмтай ижил хэмжээний үйлдлийг хөгжүүлэлт нь хийгдсээр байгаа ОпенСнитчээс хүлээх боломжгүй боловч албан ёсоор ОпенСнитч гарах үед туршаад үзэх хэрэгтэй юм.

Хэрэглэгчид ОпенСнитчийн албан ёсны 1.0.0-г хувилбарт хамаарах шинэ мэдээг GitHub repo дээрээс цаг алдалгүй татаж авч ашиглах боломжтой. Линуксийн нээлттэй эхийн програм байх философийн дагуу энэхүү шинэ програм нь GNU GPL лицензийн дор нээлттэй эхийн програм болон хөгжүүлэгдэж байгаа юм.

2017.4.24